Тухайн онд 45,274.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 41,893.6 мянган төгрөгийн хөрөнгийг хандив тусламжаар, 26,318.0 мянга, бусад байдлаар 64,358.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Тайлант онд Үндсэн хөрөнгийн зарлагын хөдөлгөөн хийгдээгүй байна.



Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	177,843.60	Хасагдсан	0.00
Худалдан авсан	45,274.00	Худалдсан	
Хандиваар	41,893.60	Акталсан	
Шилжүүлэн авсан	64,358.00	Шилжүүлсэн	
бусад	26,318.00	Бусад	

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 17,892.0 мянга, эцсийн үлдэгдэл 29,211.7 мянган төгрөг болж 18,046.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	17,892.0	29,211.7	18,046.9	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	370.9	1,171.4	800.5	4.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	30.5	17,267.4	17,236.9	59.1
Байгууллагад төлөх өглөг	17,453.6	10,726.4	(6,727.2)	36.7
Хувь хүмүүст төлөх өглөг	37.0	46.5	9.5	0.2
Дүн	17,892.0	29,211.7	18,046.9	100.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Богино хугацаат өр төлбөр нь 29,211.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЭМД-ын санхүүжилт дутуу орсонтой холбоотой сумын Эрүүл мэндийн төвийн өглөг 14,014.6 мянган төгрөг буюу 48.6 хувь, малын гоц халдвар шүлхий өвчин өвчин гарсантай холбоотой Засаг даргын Тамгын газар нь 49.9 хувь буюу 14,569.3 мянган төгрөгийн шатахууны зардлын өглөг үүссэн голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ЗДТГ		14,569.3	14,569.3	49.9
Соёл	130.8	451.2	320.4	1.5
ЭМТ	176.6	14,191.2	14,014.6	48.6
Цэцэрлэг	194.3	-	(194.3)	-
ОНХС	17,390.3	-	(17,390.3)	-
ДҮН	17,892.0	29,211.7	28,710.0	100.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,239,966.1 мянга, эцсийн үлдэгдэл 3,406,312.1 мянган төгрөг болж, 166,346.0 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,578,564.0	1,578,564.0	-	46.3
Өмч: - төрийн	1,578,564.0	1,578,564.0	-	46.3
Хуримтлагдсан үр дүн	463,395.6	629,741.6	166,346.0	18.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,198,006.5	1,198,006.5	-	35.2
Дүн	3,239,966.1	3,406,312.1	166,346.0	100.0

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн данс 166,346.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 166,346.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.



3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2020.12.16-ний өдрийн хуралдаанаар 2/03 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 50,600.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3,000.0 мянга, нийт 53,600.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.21 өдрийн Сумын ИТХ-ын 03/04 тоот тогтоолоор 11,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 62,100.0 төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	62,100.0	83,229.5	21,129.5	134.0
ИОТХ	16,500.0	14,918.7	(1,581.3)	90.4
Бууны татвар	1,800.0	1,234.0	(566.0)	68.6
Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0	888.7	(611.3)	59.2
Хадгаламжийн хүүгийн орлого	32,000.0	35,402.7	3,402.7	110.6
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого	3,000.0	2,560.0	(440.0)	85.3
Газрын төлбөр	800.0	203.0	(597.0)	25.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0	-	(6,000.0)	-
Ан агнуур нөөц ашигласны	-	27,302.4	27,302.4	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	720.0	220.0	144.0
2.Татварын бус орлого	3,000.0	1,962.8	(1,037.2)	65.4
2.1.Хүү торгуулийн орлого	3,000.0	1,962.8	(1,037.2)	65.4
Нийт дүн	65,100.0	85,192.3	(20,092.3)	130.9

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 21,129.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл хадгаламжийн хүүгийн орлого 3,402.7 мянга, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 220.0 мянган төгрөгөөр давж биелсэн бол Ан агнуур нөөц ашигласны төлбөрийг төлөвлөөгүй байсан бөгөөд тайлант онд 27302,4 мянган төгрөгийн шонхор шувуу агнасан төлбөр орсон байна. Харин бусад орлого нэр төрөл бүрдээ тасарсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод Засаг даргын Тамгын газар 1000.0 мянган төгрөгийн орлогоос 350.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 60,109.9 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 52,900.8 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

Орон нутгийн хөгжлийн санд өвс тэжээлийн борлуулсны орлого 41,127.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,236,347.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,859,357.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас мянган төгрөгийг 1,780,170.7 урсгал зардалд зарцуулж, 79,186.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн системийн дээд байгууллага нь нэг хүнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөсөн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.16-ний өдрийн 2/03 дугаар тогтоолоор нийт 2,023,683.2 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №14. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	90,629.70	111,023.0	-20,393.30
Засаг даргын Тамгын газар	393,411.10	353,108.7	40,302.40
Сургууль	759,021.10	555,771.4	203,249.70
Цэцэрлэг	234,227.70	263,744.7	-29,517.00
Эрүүл мэндийн төв	752,924.70	438,148.4	314,776.30
Соёлын төв	96,133.60	78,265.7	17,867.90
Сум хөгжүүлэх сан		65,810.0	-65,810.00
Орон нутгийн хөгжлийн сан		157,811.3	-157,811.30
Нийт дүн	2,326,347.90	2,023,683.20	302,664.70

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2020.12.16-ний өдрийн 2/03 дугаар тогтоолоор анх 2,203,683.2 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021.07.21-ний өдрийн 3/04 дугаар тогтоолоор 89,921.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан бол Ерөнхий боловсролын сургуулийн зардлыг 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар 22,800.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээр сумын нийт төсөв 2,136,404.3 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1,147,476.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 626,087.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 65,100.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 113,253.8 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 80,252.7 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 17,756.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс, 86,478.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 1,147,476.2 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилтээр 725,013.6 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээр 80,252.7 мянга, туслах үйл ажиллагааны орлогоор 94,378.1 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 17,941.0 мянган төгрөгийг санхүүжилт авч улсын төсөвт 66,223.5 мянга, орон нутгийн төсөвт 44,933.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Улсын төсөвт төвлөрүүлсэн	ОН төсөвт төвлөрүүлсэн
ИТХ	111,023.0	109,052.5	1,970.5	98.2		1970.5
ЗДТГ	416,795.8	378,077.6	38,718.2	90.7		21498.5
Сургууль	605,338.2	567,020.3	38,317.9	93.7	35,331.8	
Цэцэрлэг	250,046.6	219,333.4	30,713.2	87.7	30,267.9	
Соёлын төв	96,133.7	74,669.2	21,464.5	77.7		21464.5
Хүн эмнэлэг	438,782.4	431470.80	7,311.6	98.3	623.8	
СХСан	71,666.3	547.0	71,119.3	0.8		
ОНХСан	146,618.3	79,186.8	67,431.5	54.0		
Нийт дүн	2,136,404.3	1,859,357.6	277,046.7	87.0	66,223.5	44,933.5

Эх сурвалж: Хүрээмарал сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 87.0 хувьтай байгаа нь Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 35,331.8 мянга, цэцэрлэг 30,267.9 мянга, Засаг даргын Тамгын газар 21,498.5 мянга, Соёлын төв 21,464.5 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 67,431.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 188,424.8 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 12,912.2 мянга, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлогоос 60,490.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 25,690.3 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 45,757.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 116,847.6 мянган төгрөгийг зарцуулж 129.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	1,000.0	13,299.4	18,384.8	38,345.4	117,395.2	188,424.8
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0	13,299.4	5,472.6	38,345.4	56,905.2	115,022.6
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0		12,912.2			12,912.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	0.0				60,490.0	60,490.0
НИЙТ ЗАРЛАГА	1,000.0	13,170.4	18,384.8	38,345.4	117,395.2	188,295.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000.0	13,170.4	12,912.2	0.0	89,765.0	116,847.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж				25,690.3		25,690.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			5,472.6	12,655.1	27,630.2	45,757.9
Төсөвт төвлөрүүлсэн	0.0	129.0	0.0	0.0	0.0	129.0

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.



3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 12,000.0 төгрөг анх баталж 56,500.0 төгрөгөөр тодотгон баталж, бүрэн зарцуулсан байна.

Тайлант онд сумын засаг даргын нөөц санг 12,000.0 төгрөг анх баталж 56,500.0 төгрөгөөр тодотгон баталж, бүрэн зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 33,490.9 мянга буюу 59,3 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал, малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд, 17,181.5 мянга 30,4 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд, 5,825.6 мянга 10,3 хувийг 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 99 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 80.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнажээ.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,136,404.3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,859,357.5 мянган төгрөгийг зарцуулж, 87.0 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 10 нэр төрлийн орлогоор 65,100.0 төгрөг төвлөрүүлэхээс 10 нэр төрлийн орлогоос 85,192.3 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 134.9 хувь буюу 21,129.5 сая төгрөгөөр давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого 10,832.8 мянган төгрөгөөр төлөвлөснөөс тасарсан байна.

Хүснэгт.17 Төлөвлөгөө тасарсан орлого /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ИОТХ	16,500.00	14,918.70	-1,581.30	90.4
Бууны татвар	1,800.00	1,234.00	-566	68.6
Улсын тэмдэгийн хураамж	1,500.00	888.7	-611.3	59.2
Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого	3,000.00	2,560.00	-440	85.3
Газрын төлбөр	800	203	-597	25.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.00	-	-6,000.00	-
2.1.Хүү торгуулийн орлого	3,000.00	1,962.80	-1,037.20	65.4
Нийт дүн	32,600.00	21,767.20	-10,832.80	66.8

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Хүрээмарал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Хүрээмарал сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Зөрчилгүй	Үүнээс		
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан			Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЕБСургууль	1	1	1		1		1		
Цэцэрлэг	1	1	1		1	1			
ЗДТГ	1	1	1		1	1			
ИТХурал	1	1		1					
Соёлын төв	1	1		1					
ЭМТ	1	1	1		1	1			
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
НИЙТ ДҮН	8	8	4	4	4	3	1	0	0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан ба аудитад хамрагдсан байгууллагууд зөрчилгүй санал дүгнэлт 3 байгууллага, хязгаарлалттай саналт дүгнэлтийг 1 байгууллагад өгсөн байна.

Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 135,985.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11,010.4 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулж, 48,673.6 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 1,917.5 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 74,383.5 мянган төгрөгийн 14 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №18. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ЗДТГ	5	40,528.5	1	5,000.0	1	955.5	1	6,134.9	2	28,438.1
ЕБСургууль	5	2,939.9			1	104.2	1		3	2,835.7
Хүүхдийн цэцэрлэг	4	2,462.5	1	723.5	2	857.8	1	881.2		
Соёлын төв	5	7,526.2	3	5,286.9			1	613.7	1	1,625.6
ЭМТ	0	-								
ОНХС	4	63,383.0					2	41,043.8	2	22,339.2
СХС	0	-								
СТА зөрчлийн дүн	23	116,840.1	5.0	11,010.4	4.0	1,917.5	6.0	48,673.6	8	55,238.6
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ИТХ	1	-								1
ЗДТГ	3	2,535.0					1		2	2,535.0
Хүүхдийн цэцэрлэг	1	3,188.7							1	3,188.7
Соёлын төв	1	-					1			
ЭМТ	1	7,421.2							1	7,421.2
ОНХС	1	6,000.0							1	6,000.0
Нийцлийн аудитын дүн	8	19,144.9	-	-	-	-	2	-	6	19,144.9
Нийт дүн	31	135,985.0	5	11,010.40	4.0	1,917.5	8	48,673.6	14	74,383.5

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 116,840.1 мянган төгрөгийн 23 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 19,144.9 мянган төгрөгийн 8 зөрчил тус тус илэрсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 79,26.8 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	мэдээлээгүй
1	Бүтэн жил	12	12	11	1	0
2	Хагас жил	3	3	3	0	0
3	Улирал бүр	2	8	8	0	0
4	Сар бүр	5	60	55	5	0
5	Тухай бүр	6	72	70	2	0
Нийт		28	155	147	8	0

Эх сурвалж. Хүрээмарал сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Хүрээмарал сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Хүрээмарал сумын ЕБС нь тайлант онд улсын төсвөөс 555,771.4 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 49,566.8 мянган төгрөг нэмж 525,782.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 79,555.4 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 567,020.3 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 6.3 хувийн хэмнэлт гаргасан боловч төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Хүрээмарал сумын ЗДТГ-нь 2021 оны төсвийг 353,108.7 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 62,687.1 мянган төгрөг нэмж 415,795.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 378,077.6 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 21,498.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн

байгаа нь нийт зардлын 5.2 хувийг хэмнэсэн нь төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Хүрээмарал сумын Хүүхдийн цэцэрлэг нь Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 24,989.9 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 4,998.0 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлээр 1,809.3 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн ЗГ-ын 43 тогтоолын 1.8 дах заалттай нийцэхгүй байна.

Иймд дээрх зөрчлүүдэд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 5,266.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5,266.3 мянган төгрөгийн залруулга хийж, 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ний өдрийн 106 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	4	5,266.3	4	5,266.3			100.0
Нийт	4	5,266.3	4	5,266.3			100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Хүрээмарал сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчлийг давтан гаргахгүй байх 79,262.9 мянган төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж байна.

4.2.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2012.12.06-ны А/792 тоот захирамжаар сургуулийн төсвийг 22800,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийсэн байхад сумын ИТХ-ын хуралдаанаар өөрчлөлтийг батлаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтын дагуу тухайн сумын төсөв 22,800.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн “34.1.Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ; 34.2.1 .-д дээд шатны төсөвт тодотгол хийсний

улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж төсөвт тодотгол оруулж байх.

2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Илрүүлэлт: Нэгтгэсэн тайланд тусгасан дүн орлогын хуулганы дүн, хэлбэлзэлтэй тохирсон ба татварын хэлтэст мэдээлсэн дүн 1025,9 мянган төгрөгөөр илүү байна. Мөн ИОТХ, Бууны татвар, Улсын тэмдэгтийн хураамж, Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого, Газрын төлбөр, Хүү торгуулийн орлого 10,832.8 мянган төгрөгөөр тасарсан бол Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0 хувьтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, “5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын мэдээг орлогын дансны хуулгатай тулган мэдээлж ба Орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлж ажиллан, хог хаягдлын хураамжийн орлогыг төлөвлөж, тайлагнаж байх .

УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

Тайлант хугацаанд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллээс 8 төрлийн 78236,9 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх, удирдлагаас түүнд тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Огноо 2022	Аудитын нэр:	Хүрээмарал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/5/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Хүрээмарал сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар:					
1	Сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2012.12.06-ны А/792 тоот захирамжаар сургуулийн төсвийг 22800,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийсэн байхад сумын ИТХ-ын хуралдаанаар өөрчлөлтийг батлаагүй байна. Харин Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх хэсэгт "Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэсэн заалтын дагуу тухайн сумын төсөв 22,800.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байхад төсөвт тодотгол хийгээгүй байна.	0	Санал байхгүй	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Сумьяабазар Б.Сэрдавга
2	Нэгтгэсэн тайланд тусгасан дүн орлогын хуулганы дүн, хэлбэлзэлтэй тохирсон ба татварын хэлтэст мэдээлсэн дүн 1025,9 мянган төгрөгөөр илүү байна. Мөн ИОТХ, Бууны татвар, Улсын тэмдэгтийн хураамж, Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого, Газрын төлбөр, Хүү торгуулийн орлого 10,832.8 мянган төгрөгөөр тасарсан бол Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0 хувьтай байна.	1,025.9	Санал байхгүй	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Сумьяабазар Б.Сэрдавга
3	Тайлант хугацаанд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллээс 8 төрлийн 78236,9 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	78,237.0	Санал байхгүй	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Сумьяабазар Б.Сэрдавга
ДҮН		79,262.9			

оОо

6. Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Д/д	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	/мянган төгрөгөөр/	
				Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
А	2	3	4	Албан тушаал	Овог нэр
А	2	3	4	5	6
Засаг даргын Тамгын газар		43,063.5			
1	Тус байгууллага нь "Марал гурван очир" ХХК руу худгийн карт унших тоног төхөөрөмж суурилуулахаар 5000.0 мянган төгрөг шилжүүлсэн ч одоогоор тус тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй байна.	5,000.0	Залруулга хийсэн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Нархүү Б.Баттөмөр
2	Малын гоц халдварт шүлхий өвчин тус суманд гарсантай холбоотой эргүүл постод гарсан албан хаагчдад Зурхайч адууч хоршооноос 955.5 мянган төгрөгийн тамхи дараа тооцоогоор авч бусад хангамжийн материал дансанд бүртгэн, шаардах хуудсаар олгосон байна.	955.5	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Нархүү Б.Баттөмөр
3	Тайлант хугацаанд Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан 6134.9 мянган төгрөгийн зарцуулалтын тайланг гаргаж үр дүнг тооцоогүй байна.	6,134.9	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Нархүү Б.Баттөмөр
4	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.4-д заасан хагас жилийн санхүүгийн тайлан, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12568.2 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, орлогын 35432.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 44309.6 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Нархүү Б.Баттөмөр
5	Тайлант хугацааны мөнгөн гүйлгээний журналыг тулгахад 5672.9 мянган төгрөгийн 17 гүйлгээг и баримт болон анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн байна.	5,672.9	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Нархүү Б.Баттөмөр
6	Засаг даргын нөөц хөрөнгөөс "ТИТАНС ПИКЧУРС" ХХК-тай баримтат кино хийхээр 2535.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан 2021.09.28-ны өдөр 1000.0 мянга, 10 дугаар сард үлдэгдэл 1535.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.	2,535.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Нархүү Б.Баттөмөр
7	Санхүүгийн тайланд оны эцэст байгууллагаас авах авлага 8,195.9 мянга, бараа үйлчилгээний зардлын өглөг 9053.8 мянга, байгууллагад өгөх өглөг 5515.5 мянган төгрөг байна	22,765.2	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Нархүү Б.Баттөмөр
8	2021 оны төсвийг 353,108.7 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 62,687.1 мянган төгрөг нэмж 415,795.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 378,077.6 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 21,498.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 5.2 хувийг хэмнэсэн.	0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Нархүү Б.Баттөмөр
Хүүхдийн цэцэрлэг		5,651.2			
1	Нягтлан бодогчийн 1,3-р улирлын үр дүнгийн урамшуулал цалинг үндсэн орон тооны ажилтны цалингаас бодож илүү олгосон	357.8	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг, Д.Оюунгэрэл
2	2021 оны 7 -р сарын цалингийн санг НДХ-т илүү мэдээлсэн	881.2	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг, Д.Оюунгэрэл
3	2021 оны 8 дугаар сард олгосон урьдчилгаа цалин 500.0 мянган төгрөгийг суутгаагүй, авлагаар тусгаагүй	500.0	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг, Д.Оюунгэрэл
4	ААМ-ын материалын зарлага нярвын тайлангаас зөрүүтэй	130.0	Залруулга хийсэн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг, Д.Оюунгэрэл
5	Тооллогоорхи ААМ-ын үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 462.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нь нярав 462.0 мянган төгрөгийн кварцийн гэрлийг орлого авч, шаардахаар зарлагадсан байхад тайландаа зарлага гаргаагүй, НББ-д мөн зарлага гаргаагүй	462.0	Залруулга хийсэн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг, Д.Оюунгэрэл



Хүрээмарал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	Шатахууны орлого зарлага нярвын тайлангаас 131.5 мянган төгрөгөөр зөрүүтэй, НББ-д шууд зардлаар тайлагнасан.	131.5	Залруулга хийсэн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг, Д.Оюунгэрэл
7	Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 24,989.9 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 4,998.0 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлээр 1,809.3 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна	3,188.7	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг, Д.Оюунгэрэл
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал					
1	Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих 111023.0 мянган төгрөгийн 151 мэдээлэл байршуулахаас хагас жилийн санхүүгийн тайлан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 41644.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг тус бүр хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Батсайхан Б.Баттөмөр
Орон нутгийн хөгжлийн сан		69,382.4			
1	Сумын ИТХ-ын хурлын тогтоолоор баталсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Сум дундын Ойн ангид өгөх 17390.3 мянган төгрөгийн өвс тэжээлийн өглөгийг баталж өгөөгүй байхад 2021.06.21-д санхүүжилтийг шилжүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 дахь заалтыг зөрчсөн байна.	17,390.3	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Сумьяабазар О.Баяржаргал
2	Сумын ИТХ-ын хурлын тогтоолоор "Бүх төрлийн өвс тэжээл худалдан авах" арга хэмжээний зардалд 10000.0 мянган төгрөг баталж өгсөн байхад гүйцэтгэлээр 14948.3 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 4948.3 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.	4,948.3	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Сумьяабазар О.Баяржаргал
3	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд 2017-2018 ондолгосон малжуулахын зээлийн авлагч 76200.0 мянган төгрөгийн үлдэгдэл байгаа нь гэрээний хугацаа дууссан ч авлагыг барагдуулаагүй байна.	1,500.0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Сумьяабазар О.Баяржаргал
4	Малын өвс тэжээл бэлтгэхтэй холбоотой зардлаас 29543.8 мянга, Газар тариалангийн талбайд усалтын систем авах зардлаас 10000.0 мянган төгрөг зарцуулсан тухайн хөрөнгийг хүлээн авсан тухай акт үйлдээгүй, холбогдох байгууллагууд орлого аваагүй байна.	39,543.8	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Сумьяабазар О.Баяржаргал
5	Шилэн дансанд 6000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	6,000.0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Сумьяабазар О.Баяржаргал
Эрүүл мэндийн төв		7,421.2			
1	Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 7,421.2 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	7,421.2	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Дорждавга С.Мэндбаяр
Ерөнхий боловсролын сургууль		2,939.9			
1	Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2021 оны 03 дугаар сард нэг хүүхэд өдрийн зардлыг нормативаас 151 төгрөгөөр илүү тооцож нийт 104190 төгрөгөөр илүү зарцуулсан байна.	104.2	Төлбөрийн акт тогтоосон	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр Д.Оюунгэрэл
2	Түлш шатахууны 4 сард зарцуулсан 237.1 мянган төгрөгийн материалыг зарлагдаагүй үлдэгдлээр тайлагнасан ба хагас жилийн эд хөрөнгийн тооллогоор тоологдсон байна.	237.1	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр Д.Оюунгэрэл
3	Цалингийн зардлын гүйлгээг санхүүгийн программд тухай бүр үнэн зөв хөтлөөгүй, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас шилжүүлсэн зэргээр цалингийн зардлыг 2127.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн зөрчилд завсрын аудитаар зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй цалингийн зардлыг 2598.6 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.	2,598.6	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр Д.Оюунгэрэл
4	Шилэн дансны цахим хуудаст Нийт 827643.9 мянган төгрөгийн 151 мэдээлэл мэдээлэхээс 4-р улирлын төсвийн байгууллагын батлагдсан төсөв,	0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр Д.Оюунгэрэл

Хүрээмарал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй байна.				
5	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчиж батлагдсан төсөвт зардлын дунд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй.	0	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Б.Ууганбаяр Д.Оюунгэрэл
Соёлын төв		7,526.2			
1	Цалингийн зардлаас 09 дүгээр сард Монголын цахилгаан холбоо ХХК-д 612.3 мянган төгрөгийн НДХ-т шилжүүлэх гүйлгээг төрийн сангийн мэргэжилтэн шилжүүлсэн байна.	612.3	3-р улирлын санхүүгийн тайланд залуулгах хийсэн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Батхолбоо О.Баяржаргал
2	Цалингийн зардлыг санхүүгийн программд тухай бүр үнэн зөв хөтлөөгүй, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас шилжүүлсэн зэргээр цалингийн зардлыг 1559.0 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 3032.4 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн байна.	4,591.4	3-р улирлын санхүүгийн тайланд залуулгах хийсэн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Батхолбоо О.Баяржаргал
3	Тээвэр шатахуун зардлаас Эм Би Өү Ай Эл ХХК-аас 553.7 мянган төгрөгийн шатахуун авч 470.5 мянган төгрөг шилжүүлэн 83.2 мянган төгрөгийн өглөг үүссэн ч санхүүгийн тайланд бүртгээгүй 100.7 мянган төгрөгийн шатахууныг орлого аваагүй.	83.2	3-р улирлын санхүүгийн тайланд залуулгах хийсэн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Батхолбоо О.Баяржаргал
4	Тайлант хугацаанд 1258.4 мянган төгрөгийн халаалтын зардлын гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн, 352.2 мянган төгрөгийн бичиг хэрэг, шатахууны гүйлгээг анхан шатны баримтгүй хийсэн, 15.0 мянган төгрөгийн цахилгааны төлбөрийг шуудан холбооны зардлаас төлсөн.	1,625.6	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Батхолбоо О.Баяржаргал
5	Шатахууны тайлан гаргахдаа 613.7 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын баримтыг бүрдүүлж хавсаргаагүй байна.	613.7	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Батхолбоо О.Баяржаргал
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.4-д заасан санхүүгийн тайлан / бүтэн жилээр/, 6.4.5-д заасан 7,735.5 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 20914.5 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.	0	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, нягтлан бодогч	С.Батхолбоо О.Баяржаргал
Нийт дүн		130,690.9			

оОо